



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2016 оны 02 сарын 05 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Тариф хянан батлах тухай

Монгол Улсын “Харилцаа холбооны тухай” хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.5 дахь хэсэг, “Өрсөлдөөний тухай” хуулийн 7.1.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Монгол Улсын үүрэн телефон холбооны үйлчилгээний зах зээлд давамгайлагч үйлчилгээ эрхлэгчийн “Үүрэн телефон холбооны үйлчилгээний стандарт үнэ тарифын доод хязгаар”-ыг хавсралтаар баталсугай.
2. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан тус хоорооны 2007 оны 28 дугаар тогтоол, 2009 оны 63 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.
3. Батлагдсан “Үүрэн телефон холбооны үйлчилгээний стандарт үнэ тарифын доод хязгаар”-ыг мөрдөн ажиллах, энэхүү доод хязгаараас хямдруулах урамшуулал, хөнгөлөлтийн хугацааг жилд 90 хоногоос хэтрүүлэхгүй байхыг үйлчилгээ эрхлэгчдэд үүрэг болгосугай.
4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга /Б.Балгансүрэн/-д даалгасугай.

ДАРГА

Б.БАЛГАНСҮРЭН

ГИШҮҮД

Д.АМГАЛАНБААТАР


Н.БАТТОГТОХ

Ч.ДАВААЖАМЦ

Ц.ЖАДАМБАА

Б.МӨНХБАТ

Р.ОТГОНТУЛГА



Харилцаа холбооны зохицуулах хорооны
2016 оны 2 дугаар сарын 05-ны өдрийн
01 тоот тогтоолын
хавсралт

**“Үүрэн телефон холбооны үйлчилгээний стандарт үнэ тарифын
доод хязгаар”**

1. Үүрэн телефон холбооны үйлчилгээний зах зээлд давамгайлагч үйлчилгээ эрхлэгчдийн үйлчилгээний ярианы үйлчилгээний 1 минутын стандарт* үнэ тарифын* доод хязгаар:

№	Үйлчилгээний төрөл	Сүлжээ дотор /төгрөг/	Бусад сүлжээ рүү /төгрөг/
1	Дараа төлбөрт үйлчилгээ	45 ₮	60 ₮
2	Урьдчилсан төлбөрт үйлчилгээ	50 ₮	63 ₮

2. Үүрэн телефон холбооны үйлчилгээний зах зээлд давамгайлагч үйлчилгээ эрхлэгчдийн урамшуулалт үйлчилгээний 1 минутын стандарт* үнэ тарифын доод хязгаар:

№	Үйлчилгээний төрөл	Сүлжээ дотор /төгрөг/	Бусад сүлжээ рүү /төгрөг/
1	Ярианы үйлчилгээ	10 ₮	30₮

*Стандарт тариф – Багцын хэрэглээнд тооцогдоогүй задгай тариф
* * Тариф – НӨАТ ороогүй дүн